


Шинэ хэрэглэгчид олох хэрэгтэй байна уу? *Сайн туршилагаас суралцаарай.*

Европын Холбоо, ЕСБХБ-ны Хувь Нийлүүлсэн Тусгай Сангийн санхүүжилтээр бид Монгол улсын ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Ашид Нэхмэл компанид бүтээгдэхүүнээ шинэчлэн, хэрэглэгчдийн цар хүрээг тэлж, борлуулалтын хэмжээгээ 228% нэмэгдүүлэхэд тусаллаа.



Ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэр, Монгол улс

Бид Монгол улсын ноос, ноолууран бүтээгдэхүүний Ашид Нэхмэл компанид шинэ брэндийн стратеги төлөвлөгөө, брэндийн таних тэмдэг боловсруулах, вэбсайт хийхэд тусалсанаар шинэ хэрэглэгчидтэй болж экспортын борлуулалт нь 304%-иар нэмэгдсэн.

Ашид Нэхмэл ХХК нь 2011 онд байгуулагдсан ба ноос, ноолууран нэхмэл бүтээгдэхүүнд зориулсан дэвшилтэт машин техникээр тоноглогдсон Монголын тэргүүлэх зэргийн нэхмэлийн үйлдвэр юм. Компани нь Монгол улсын хамгийн өндөр чанартай, дотоодод үйлдвэрлэгдсэн хонины нарийн ноосоор олон өнгийн, төрөл бүрийн сүлжмэл ба нэхмэл бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг.

Компани нь сургуулийн сурагчдын формын хувцасны ноосон утас болон малчдын гадуур хувцсыг оёход шаардагддаг хөвөн даавуу болон ноосон материалыг үйлдвэрлэн нийлүүлдэг.



Бид Монгол улсын ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Ашид Нэхмэл компанид бүтээгдэхүүнээ шинэчлэн сайжруулахад нь тусалсанаар шинэ хэрэглэгчидтэй болж экспортын борлуулалт нь нэмэгдсэн.

Тус компани гадаадын болон дотоодын зах зээлд тохирсон төрөл бүрийн тансаг, өнгөлөг, нэхмэл болон сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зорьсон. Ялангуяа тэд Европын зах зээлийг өндөр чанарын нэхмэл ба сүлжмэл эко бүтээгдэхүүнүүдээр хангахаар хичээн ажиллаж байна. Үүнийг хийхийн тулд Ашид Нэхмэл компани нь онлайн маркетингийн арга хэрэгсэл ашиглан олон улсын зах зээлд экспортын худалдаагаа өргөжүүлэх шаардлагатай болсон юм.

Бид компанийг дотоодын маркетингийн зөвлөх Нью Медиа Групп компанитай холбож өгсөн ба зөвлөх нь:

- Компаний зорилт, норм стандарт болон зах зээлд эзлэх байр суурьд үнэлгээ хийсэн.
- Компанид тохирсон брэндийн стратеги боловсруулсан.
- Брэндийн Таних Тэмдэгийн Зааварчилгааны дагуу компаний брэндийн таних тэмдэгийг боловсруулсан.
- Хэрэглэгчид ээлтэй вэб-сайт хийсэн.

Үүний үр дүнд Ашид Нэхмэл ХХК цахим борлуулалтын сувгаа амжилттай нээн илрүүлж, дэлхийн зах зээл дээр шинэ брэнд нэвтрүүлэн, дотоодын ба олон улсын зах зээлийн аль алинд нь брэндээ таниулан, жижиглэн худалдаачид болон хэрэглэгчдийн илүү өргөн хүрээг татаж чадсан. Төсөл дууссанаас хойш нэг жилийн дараа компаний борлуулалтын хэмжээ 228% нэмэгдсэнээс экспортын борлуулалт 304%-иар өссөн байна.

Борлуулалтын орлого

+301%

Борлуулалтын хэмжээ

+228%

Экспортын борлуулалт

+304%

Төслийн нийт санхүүжилт

€13,398

Үйлчлүүлэгчээс гарсан зардал

€7,308

www.ebrd.com/knowhow

